

2025 оны 01 сарын 17-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны болон
сургалтын төлөвлөгөө батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн “Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Нэгдүгээр хавсралтаар, “Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан 2025 оны сургалтын төлөвлөгөө”-г Хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, жилийн ажлын гүйцэтгэлийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулах, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Цэлмэг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ




Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 1 дүгээр сарын
17-ны өдрийн 01 тоот Тогтоолын Хавсралт №02



**"СЭНДЛИ" ББСБ ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД
ЗОРИУЛСАН 2025 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Сургалтын нэр	Хийгдэх хугацаа	Хариуцсан байгууллага, ажилтан	Тайлбар
1	Чиглүүлэх сургалт	тухай бүр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	ТУЗ-ийн гишүүд өөрчлөгдөх тохиолдолд шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдэд зориулсан сургалт
2	Удирдах ажилтны сургалт	4 эсхүл 12 дугаар сард	Сэндли ББСБ ХК-ийн сургалт хариуцсан ажилтан	Компанийн хэмжээнд нийт удирдах ажилтнуудад зориулсан
3	Компанийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулах сургалт	6 болон 12 дугаар саруудад	Сэндли ББСБ ХК-ийн сургалт хариуцсан ажилтан	Компанийн үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлж байгаа бүтээгдэхүүн үйлчилгээг таниулах зорилготой.